

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ
ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТУХАЙ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА**

2018 оны 06 дугаар
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарь

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан, Л.Мөнхбаатар, Б.Дэлгэрсайхан нараас 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаараа Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж, нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхийн дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хувилбарын төслийг бэлтгэлээ.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1-д заасны дагуу хуулийн дагаж мөрдөх хугацааг 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс дагаж мөрдөх саналыг хэлэлцэж, дэмжсэн болно.

Түүнчлэн дээрх асуудлыг хэлэлцэх явцад Байнгын хорооны гишүүд Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дагаж мөрдөх журмын тухай хууль гаргах шаардлагагүй гэж үзсэн болно.


Байнгын хорооноос Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, саналын томъёоллыг бэлтгэн Та бүхэнд тараасан байгаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга болон саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ш.РАДНААСЭД

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ТАЛААРХИ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан:Байнгын хороо

Хууль зүйн байнгын хороо

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

~~1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “гэмт хэрэг” гэснийг “Гэмт хэрэг” гэж өөрчилсүгэй.~~

~~2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 8.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хөнгөн”, 8.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Хөнгөн” гэснийг тус тус хассугай.~~

1 дүгээр зүйл. 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Хүнд” гэснийг “Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жил, түүнээс дээш хугацаагаар тогтоосон” гэж, 8.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хөнгөн” гэснийг “энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагагүй” гэж, 8.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Хөнгөн” гэснийг “Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагагүй” гэж тус тус өөрчилсүгэй.

~~3 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг хүчингүй болгоногдоо тус тус хассугай.~~

Гарын үсэг